



МОНГОЛ УЛСЫН  
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙДЫН  
ТУШААЛ

2019 оны 08 сарын 22 өдөр

Дугаар A767

Улаанбаатар хот

Г Яамны бэлгэдлийг үйлдэх,  
хэрэглэх журмыг батлах тухай

Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.6.1 дэх заалт, 9.8 дахь хэсэг, Гадаад харилцааны сайдын зөвлөлийн 2019 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаас гаргасан зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Гадаад харилцааны яамны бэлгэдлийн загвар, түүнийг хэрэглэх журмыг 1 дүгээр хавсралтаар, бэлгэдлийг үйлдэх зааврыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Бэлгэдлийн загварыг холбогдох хууль тогтоомжийн дагуу Оюуны өмчийн газарт бүртгүүлэхийг Төрийн захиргааны удирдлагын газрын захирал Н.Анхбаярт, журмыг нийт Дипломат төлөөлөгчийн газарт хүргүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавихыг Гадаад сурталчилгаа, соёлын харилцааны газрын захирал Х.Мандахцэцэгт нарт тус тус үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан “Яамны бэлгэдлийн загвар, түүний тодорхойлолт, хэрэглэх журам батлах” тухай Гадаад хэргийн сайдын 2008 оны 03 сарын 10-ны өдрийн 18 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Д.ЦОГТБААТАР



Гадаад харилцааны сайдын 2019 оны 08 сарын 12-ны өдрийн дугаар  
Аж тушаалын Нэгдүгээр хавсралт



## ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМНЫ БЭЛГЭДЛИЙН ЗАГВАР, ТҮҮНИЙГ ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

### НЭГ. Нийтлэг үндэслэл

Гадаад харилцааны яамны бэлгэдэл нь Монгол Улсын энхийг эрхэмлэгч гадаад бодлого, дипломат албаны түүхэн уламжлал, түүний үйл ажиллагаа өнө мөнхөд батжин оршихын илэрхийлэл бөгөөд энэхүү журам болон бэлгэдлийн үйлдэх заавраар Гадаад харилцааны яамны бэлгэдэл, түүнийг үйлдэх, хэрэглэх үйл ажиллагааг зохицуулна.

#### Бэлгэдлийн агуулга

- 1.1. Бэлгэдэл нь “Соёмбо”, “Гэрэгэ”, “Дэлхийн бөмбөрцөг”, “Гадаад харилцааны яам” гэсэн бичиглэлээс бүрдэнэ.
- 1.3. “Соёмбо” нь Монгол Улсын тусгаар тогтол, бүрэн эрхт байдал, цог хийморийг илэрхийлэл юм.
- 1.4. “Гэрэгэ” нь Монголын эзэнт гүрний хаад харь улсад зорчих элч, төлөөлөгчиддөө шийтгэн олгож байсан тэдний халдашгүй дархан эрхийн баталгаа юм.
- 1.5. “Дэлхийн бөмбөрцөг” нь Монгол Улс дэлхийн улсуудтай найрсаг харилцаатай байхын илэрхийлэл юм.
- 1.6. “Гадаад харилцааны яам” бүхий бичвэр нь бэлгэдлийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд бэлгэдлийг тодотгож буй юм.

#### ХОЁР. Бэлгэдлийг хэрэглэх

- 2.1. Бэлгэдлийг Гадаад харилцааны яамны төв байрны хуралдаан, уулзалт, ёслол хүндэтгэлийн зориулалт бүхий өрөө, танхимд байрлуулна. Монгол Улсаас хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын байранд байрлуулж болно.
- 2.2. Бэлгэдлийг энгэрийн тэмдэг хэлбэрээр үйлдэж, Гадаад харилцааны яам болон хилийн чанад дахь Дипломат төлөөлөгчийн газарт ажиллаж буй төрийн албан хаагчид хүндэтгэлтэйгээр зүүнэ.
- 2.3. Дипломат албаны ой, тэмдэглэлт өдөр, Гадаад харилцааны яамны шугамаар зохиогдож буй олон улсын хурал, зөвлөгөөн, тэдгээртэй адилтгах бусад арга хэмжээний үед тухайн арга хэмжээ болж байгаа танхим, тасалгаанд бэлгэдлийг байрлуулж болно.

- 2.4. Гадаад харилцааны яам нь Дипломат цолны батламж бичиг, Өргөмжлөл, яамны бодлого үйл ажиллагааны талаар нийтэд мэдээлж байх зорилгоор гаргаж буй эмхэтгэл, албан ёсны цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, үнэмлэх, ил захидал, тэмдэглэлийн дэвтэр, хуанли, урилга, дугтуй, бэлгийн уут зэрэг бэлэг дурсгал болон сурталчилгааны бусад зүйл дээр бэлгэдлийг дүрсэлж болно.
- 2.5. Бэлгэдлийг Гадаад харилцааны яамны бүтцийн нэгж болон Дипломат төлөөлөгчийн газрын нэртэй давхар хэрэглэж болно.
- 2.6. Бусад хуулийн этгээд, иргэн бэлгэдлийг дүрслэх буюу хувилан олшруулах тохиолдолд Гадаад харилцааны яамнаас урьдчилан зөвшөөрөл авах үүрэгтэй бөгөөд бэлгэдлийг хэрэглэхдээ энэ журмыг чанд мөрдөнө.
- 2.7. Бэлгэдлийг хэрэглэхдээ түүний хэмжээнээс үл хамааран баталсан эх загварыг чанд баримтална.

#### **ГУРАВ. Бэлгэдлийг хамгаалах**

- 3.1. Бэлгэдлийг энэхүү журмаар зөвшөөрөгдсөнөөс бусад хуулийн этгээд хэрэглэхийг хориглоно.
- 3.2. Бэлгэдлийг үйлдэх, хэрэглэх журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий албан тушаалтан, улсын байцаагч хариуцлага хүлээлгэнэ.
- 3.3. Энэхүү журмын биелэлтэд Оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хуулиар олгосон эрх хэмжээний хүрээнд хяналт тавина.